



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/240

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “б” заалт, Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.1.35 дугаартай Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад тусгагдсан “Засаг даргын Тамгын газрын барилга (Өвөрхангай, Тарагт сум)”-д зарцуулах төсөл, арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын барилга (Өвөрхангай, Тарагт сум) зарцуулах 500000000 (таван зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100583